



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/87

Баянхутаг сум

**ЦЭРЭГ ТАТЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХ
ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12, 13 дугаар зүйл, Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/155 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 2025 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр зохион байгуулсугай.

2. Цэрэг татлагын товчоог доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Товчооны дарга: Г.Болд – Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Б.Бат-Эрдэнэ – БГТХМэргэжилтэн

Б.Энхтуул – Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн

А.Чимэддондов – Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын
мэргэжилтэн

Д.Буянбат – Жаргалант багийн Засаг дарга

Д.Алтанчимэг – Улаан-Өндөр багийн Засаг дарга

Б.Алтангэрэл – Цантын хоолой багийн Засаг дарга

Ц.Ганзориг – Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

С.Мөнххэрлэн – Соёлын төвийн дарга

Э.Заяабаатар – Хэсгийн төлөөлөгч

М.Энхбаяр – Архив, бичиг хэргийн эрхлэгч

3. Зарлан дуудах хуудсыг нэрсийн жагсаалтад заасан цэргийн албанд татагдагч бүрт хүргүүлэн, заасан хугацаанд Цэрэг татлагын байранд бэлэн байлгахыг багийн Засаг дарга нарт, Цэрэг татлагын байрыг 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр бэлтгэхийг Соёлын төв /С.Мөнххэрлэн/, Цэрэг татлагын үед

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, цэрэг татлагыг хууль, журмын хүрээнд зохион байгуулахыг Цэрэг татлагын товчооны дарга /Г.Болд/-д үүрэг болгосугай.